



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2009 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

“Сайн дурын даатгалын хэлбэр”-ийг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Сайн дурын даатгалын хэлбэр”-ийг 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Сайн дурын ердийн даатгалын хэлбэр”-ийг батлах тухай Хорооны 2006 оны 18 дугаар тогтоол, “Урт хугацааны сайн дурын даатгалын хэлбэрийн жагсаалт”-ыг батлах тухай Хорооны 2007 оны 172 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Шинэчлэгдэн батлагдсан даатгалын хэлбэрт энэхүү тогтоолын 2 дахь заалтаар хүчингүй болсон даатгалын хэлбэрүүдийг хэрхэн хамааруулах аргачлалыг боловсруулж, нэгдсэн заавар гарган даатгалын компаниудад албан ёсоор мэдэгдэж, мөрдүүлэхийг Даатгалын газар /С. Ганболд/-г даалгасугай.
4. Даатгалын хэлбэр тус бүрийн нөөцийн сангуудын 2009 оны эхний үлдэгдлийг энэхүү тогтоолоор батлагдсан даатгалын хэлбэрт хамааруулан тооцохыг Даатгалын компаниудад үүрэг болгосугай.
5. Даатгалын компаниудын даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С. Ганболд/, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон даатгалын хэлбэрийг Даатгалын компаниудын тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд шинэчлэн бүртгэж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н. Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Сайн дурын даатгалын хэлбэр

Даатгалын ангил	Даатгалын хэлбэр
1. Ердийн даатгал	1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал
	1.2. Хөрөнгийн даатгал
	1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал
	1.4. Ачааны даатгал
	1.5. Барилга угсралтын даатгал
	1.6. Газар тариалангийн даатгал
	1.7. Мал амьтдын даатгал
	1.8. Агаарын хөлгийн даатгал
	1.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал
	1.10. Хариуцлагын даатгал
	1.11. Санхүүгийн даатгал
2. Урт хугацааны даатгал	2.1. Хугацаат амьдралын даатгал
	2.2. Насан туршийн даатгал
	2.3. Хуримтлалын даатгал
	2.4. Тэтгэврийн даатгал
	2.5. Эрүүл мэндийн даатгал
	2.6. Аннуити даатгал

Тайлбар:

Даатгалын хэлбэр нь даатгалын бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Даатгалын бүтээгдэхүүн гэдэгт даатгагчаас даатгалын зах зээлд санал болгож байгаа даатгалын үйлчилгээг ойлгоно. Жишээлбэл: Хүүхдийн гэнэтийн ослын даатгал нь Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын хэлбэрт хамаарах даатгалын бүтээгдэхүүн юм.

***Урт хугацааны сайн дурын даатгалын хэлбэрүүдийн нэр томъёоны тайлбар:**

Хуримтлалын даатгал (Endowment) гэдэгт даатгуулагч гэрээт хугацааны эцэст амьд байх болон тухайн хугацаанаас өмнө нас барах гэсэн нөхцөлүүдээр даатгагчаас даатгуулагч, эсвэл гэрээнд заагдсан эрх бүхий этгээдэд баталгаатай мөнгөн төлбөрийг төлөх хугацаат даатгал болон хөрөнгө оруулалтын хавсарсан даатгалыг;

Насан туршийн даатгал (Whole life) гэдэгт даатгуулагч зөвхөн нас барсан нөхцөлд даатгагчаас даатгалын гэрээнд заагдсан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгалыг;

Хугацаат амьдралын даатгал (Term life) гэдэгт зөвхөн даатгалтай хугацаанд даатгуулагч нас барсан нөхцөлд даатгагчаас даатгалын гэрээнд заагдсан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгалыг;

Тэтгэврийн даатгал (Pension) гэдэгт даатгалын гэрээгээр даатгагчаас даатгуулагчид тэтгэвэр олгохоор тохиролцсон хугацаанд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгалыг;

Эрүүл мэндийн даатгал (Private health) гэдэгт эрүүл мэндийн холбогдолтой зардлыг 1 жилээс дээш хугацаа бүхий даатгалын гэрээгээр даатгагчаас даатгуулагчид төлөх нөхцөл бүхий даатгалыг (хөдөлмөрийн чадвар алдалт хамаарна).

Аннуити даатгал /Annuity/ гэдэгт даатгагчаас даатгуулагчид гэрээгээр тохиролцсон хугацаанд үечилсэн байдлаар тогтмол мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгалыг хэлнэ.